

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
Менежментийн захидал	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Т.ЭНХЗАЯА ТАНАА

2020.03.23 № 06/913
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Т.Энхзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 16-наас 2020 оны 03 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийг дэмжих сан 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 2/1043 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга, нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

Мөн эрүүл аюулгүй амьдралын орчин бүрдүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийг хамгаалах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх эмийн зохистой хэрэглээ зэрэг үйл ажиллагаанд анхаарч ажилладаг байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Гүүк софт ХХК-ийн Аксплорер программ хангамж ашигладаг байна.

Сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,999.1 сая төгрөгөөс тооцон 59.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 5.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/				
дд	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
3	АВЛАГА		5,346.3	5,346.3
4	УРЬДЧИЛГАА	24,300.0	24,300.0	-
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,300.0	29,646.3	5,346.3
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,187.1	2,187.1
15	Хуримтлагдсан үр дүн	24,300.0	27,459.2	3,159.2
17	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	24,300.0	29,646.3	5,346.3

Авлага болон өр төлбөрийн дансны үлдэгдэлд АШУҮИС-ийн хэрэгжүүлсэн төслийн төлбөрийн үлдэгдэл 2.1 сая төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар байгууллагад өгөх өр төлбөрөөр бүртгэсэн байна. Мөн Сэтгэлийн үр ТББ-аас авах 3.1 сая төгрөгийн авлага тайлагнасан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Сангийн хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрт зориулан 3,000.0 сая төгрөгийн төсөв батлагдсаныг бараа, үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 32.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн. Үүнд:

- ДЭМБ-ын 72 дугаар чуулганд оролцсон төлөөлөгчдөд 0.9 сая төгрөгийн замын зардал илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад эргэн төлүүлж, зөрчлийг арилгасан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

АШУҮИС-ийн “Уламжлалт анагаах ухааны 108 боть бүтээлийг хэвлүүлэх” төслийн санхүүжилт 297.8 сая төгрөгийг олгосон боловч гэрээнд заасан хугацаанд дээрх ботиуд хэвлэгдэж гараагүй байна. Дараагийн аудитаар гэрээт ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн эсэхийг шалгах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийг дэмжих сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус сан нь шилэн дансны цахим хуудсанд заасан дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй, 35.7 сая төгрөгийн зэрчилд 5 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Урьдчилж гарсан зардалын данстай холбоотой асуудал*

1.1 Илрүүлэлт:

Урьдчилж гарсан зардал дансны эхний болон эцсийн үлдэгдэл 24.3 сая төгрөг тайлагнасан нь өмнөх онд хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтээс гүйцэтгэл гараагүй үлдэгдэл бөгөөд эзэн холбогдогч нь тодорхойгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

2. *Авлагын данстай холбоотой асуудал*

2.1 Илрүүлэлт:

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах богино хугацааны сургалтын төслийн гүйцэтгэлийг актаар хүлээн авч нийт 41.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч 38.6 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч 3.1 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

2.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг мөрдөж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

3. Томилолтын зардалтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

ЭМС-ын 2019 оны А/192 дугаар тушаалаар Хонконг улсад зохион байгуулагдсан 4 хоногийн сургалтад 4.8 сая төгрөгийн томилолтын зардал олгосон нь Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээнээс 0.2 сая төгрөгөөр илүү байна.

3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөж ажиллах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд Сангийн үйл ажиллагаатай холбоотой гарч буй тушаал шийдвэр, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байршуулаагүй байна.

4.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийн зарцуулалт ил тод, нээлттэй бус байх

4.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,300,000.00	29,646,379.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	5,346,379.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,187,144.00
335	Бусад авлага	-	3,159,235.00
3351	Байгууллагаас авах авлага	-	3,159,235.00
34	УРЬДЧИЛГАА	24,300,000.00	24,300,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	24,300,000.00	24,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	=	=
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,300,000.00	29,646,379.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,187,144.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,187,144.00
413	Өглөг	-	2,187,144.00
4136	Бусад өглөг	-	2,187,144.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,187,144.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,300,000.00	27,459,235.00
51	Засгийн газрын хувь оролцоо	24,300,000.00	27,459,235.00
512	Хуримтлагдсан үр дүн	24,300,000.00	27,459,235.00
51210	Өмнөх үеийн үр дүн	146,800,000.00	24,300,000.00
51220	Тайлант үеийн үр дүн	(122,500,000.00)	3,159,235.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,300,000.00	29,646,379.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,000,000,000.00	3,002,234,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,234,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,234,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,234,700.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,234,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,000,000,000.00	3,000,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,000,000,000.00	3,000,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,000,000,000.00	3,000,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,121,500,000.00	2,999,027,909.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,121,500,000.00	2,999,027,909.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	47,556.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	47,556.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	47,556.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(122,500,000.00)	3,159,235.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(122,500,000.00)	3,159,235.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,001,000,000.00	3,002,234,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	2,234,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	2,234,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	2,234,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,234,700.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,000,000,000.00	3,000,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,000,000,000.00	3,000,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,000,000,000.00	3,000,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,001,000,000.00	3,002,234,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,001,000,000.00	3,002,234,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000,000.00	3,000,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000,000.00	3,000,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000,000.00	3,000,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	2,234,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,234,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,234,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	24,300,000.00	24,300,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	24,300,000.00	24,300,000.00
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	24,300,000.00	24,300,000.00
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	24,300,000.00	24,300,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	24,300,000.00	24,300,000.00
Тайлант үеийн үр дүн	0.00	3,159,235.00	3,159,235.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	27,459,235.00	27,459,235.00

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	/төгрөгөөр/ Зөрүү Хувь	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
УРСГАЛ ЗАРДАЛ	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
Тусламж санхүүжилтийн орлого	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
Улсын төсвөөс санхүүжих	3,000,000,000.00	2,999,952,444.00	47,556.00	99.99
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020-03-23	Аудитын нэр:	Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
				САГ-2020/7/СТА-3ГТС
Шалгагдсан байгууллагын нэр:		ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САН		Мянган төгрөгөөр

Д Д	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
	1		2	3	4	5
1	Урьдчилж гарсан зардал	Он дамжсан эзэн холбогдогч тодорхойгүй УГЗ байна.	24,300.0		НЭМГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Т.Энхзаяа Х.Отгонзул
2	Авлага	Тайлангийн гүйцэтгэлийг бодитой хянаагүй санхүүжилт олгосноос авлага үүссэн	3,159.2			
3	Томилолтын зардал	Гадаад томилолтын зардлыг илүү олгосон	4,800.0			
4	Шилэн данс	Шилэн дансанд мэдээлэл бүрэн байршуулаагүй	-			
		ДҮН	32,259.2			

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.